

I-V/2021


Тархаасан: 2021 оны 6 дугаар сарын 14



Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2021 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 5.9 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 5.3 их наяд төгрөг байна. Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь нийт орлогын 90.6 хувийг эзэлж байна.

Зураг 1. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, тэрбум төгрөг



Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 6.2 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 866.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 2021 оны 5 дугаар сард 860.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 956.2 (52.6%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 194.2 (29.1%) тэрбум төгрөгөөр өсжээ. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 1.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 974.5 (44.1%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 365.3 (22.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 6.2 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 866.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2021 оны 5 дугаар сард 375.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх сараас 18.4 (4.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 78.0 хувийг татварын орлого, 12.7 хувийг татварын бус орлого, 5.6 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 3.7 хувийг тогтворжуулалтын сангийн орлого тус тус эзэлж, өмнөх оны мөн үеэс татварын бус орлогын эзлэх хувь 4.6 хувь, тогтворжуулалтын сангийн орлого 3.5 пунктээр өсөж, татварын орлого 7.8 пункт, ирээдүйн өв сангийн орлого 0.3 пунктээр буурсан байна.

Татварын нийт орлого 2021 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 4.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.5 (49.4%) их наяд төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 850.3 (2.1 дахин) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 317.1 (43.4%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 112.9 (44.1%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 81.6 (30.7%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 100.2 (14.6%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 36.5 (13.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.


Татварын нийт орлого 2021 оны 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 777.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 606.3 (43.8%) тэрбум төгрөгөөр буурахад орлогын албан татвар 676.9 (82.1%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 120.2 (77.9%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Харин нэмэгдсэн өртгийн албан татвар 136.9 (2.1 дахин) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 26.7 (45.7%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 13.5 (8.6%) тэрбум төгрөг, онцгой албан татварын орлого 8.4 (17.5%) тэрбум төгрөг, хөрөнгийн албан татварын орлого 4.9 (49.7%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хүснэгт 1. Улсын нэгдсэн төсвийн орлого, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018 I-V	2019 I-V	2020 I-V	2021 I-V*	<u>2021* I-V</u> <u>2020 I-V</u>
Нийт орлого, тусламжийн хэмжээ	3 659.5	4 398.0	3 564.0	5 854.1	164.3
Ирээдүйн өв сан	263.7	421.2	211.0	329.7	156.3
Тогтворжуулалтын сан	90.3	24.9	9.6	218.7	22.8 ¹
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн хэмжээ	3 305.5	3 951.9	3 343.4	5 305.8	158.7
Татварын орлого	2 949.2	3 588.9	3 055.6	4 563.5	149.4
Орлогын албан татвар	765.5	960.9	773.8	1 624.1	2.1 ¹
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	488.7	654.0	449.6	1 242.7	2.8 ¹
Хувь хүний орлогын албан татвар	313.6	337.3	348.1	410.4	117.9
Нийгмийн даатгалын орлого	565.1	746.1	686.0	786.2	114.6
Хөрөнгийн албан татвар	58.5	55.7	57.4	67.4	117.3
Нэмэгдсэн өртгийн албан татвар	754.9	815.7	731.0	1 048.1	143.4
Онцгой албан татвар	274.5	342.7	280.0	316.5	113.0
Тусгай зориулалтын орлого	4.5	6.5	5.8	5.2	88.9
Гадаад үйл ажиллагааны орлого	240.6	289.2	265.6	347.3	130.7
Бусад татвар, төлбөр, хураамж	285.5	372.1	255.9	368.8	144.1
Татварын бус орлого	356.3	363.0	287.9	742.3	2.6 ¹
Нийтлэг татварын бус орлого	351.5	354.3	280.6	706.7	2.5 ¹
Хөрөнгийн орлого	0.4	0.3	0.3	0.3	121.6
Тусламжийн орлого	4.4	8.4	7.0	35.2	5.0 ¹


¹ Дахин их

Зураг 2. Улсын нэгдсэн төсвийн татварын орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар



Татварын нийт орлогод орлогын албан татварын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 10.3 пунктээр өсөж, бусад татварынх 0.7 пункт, нийгмийн даатгалын орлогынх 5.3 пункт, онцгой албан татварынх 2.3 пункт, гадаад үйл ажиллагааны орлогынх 1.1 пункт, нэмэгдсэн өртгийн албан татварынх 0.9 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 3. Улсын нэгдсэн төсвийн татварын болон татварын бус орлого, нийт зарлага, цэвэр зээл, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, тэрбум төгрөг



Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2021 оны эхний 5 сарын байдлаар 6.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (25.4%) их наяд төгрөгөөр өссөн байна. Зарлагын өсөлтөд урсгал зардал өмнөх оны мөн үеэс 1.4 (33.9%) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Харин хөрөнгийн зардал 153.5 (18.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна.


Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2021 оны 5 дугаар сард 1.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 974.5 (44.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Улсын нэгдсэн төсвийн зардал буурахад урсгал зардал 861.3 (43.9%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 128.0 (51.4%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээл, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018 I-V	2019 I-V	2020 I-V	2021 I-V*	$\frac{2021^* I-V}{2020 I-V}$
Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ	3 260.0	3 805.8	4 922.3	6 172.1	125.4
Нийт зарлага	3 176.6	3 727.8	4 902.7	6 132.7	125.1
Урсгал зардал	2 859.0	3 203.7	4 076.9	5 460.4	133.9
Бараа, ажил үйлчилгээний зардал	1 225.3	1 488.9	1 732.9	1 611.8	93.0
Хүү	430.6	355.3	337.9	341.9	101.2
Татаас	98.0	102.0	343.7	170.9	49.7
Урсгал шилжүүлэг	1 105.2	1 257.6	1 662.4	3 335.8	2.0 ¹
Засгийн газрын урсгал шилжүүлэг	41.5	29.6	42.4	278.6	6.6 ¹
Бусад урсгал шилжүүлэг	1 063.7	1 228.0	1 620.0	3 057.2	188.7
Хөрөнгийн зардал	317.6	524.0	825.8	672.3	81.4
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	83.5	78.1	19.5	39.4	2.0 ¹
Эргэж төлөгдөх цэвэр зээл	59.3	41.8	- 9.2	14.6	-
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	24.2	36.2	28.7	24.8	86.2

¹ Дахин их

Зураг 4. Улсын нэгдсэн төсвийн үрсгал зардлын бүтэц, дүнд эзлэх хувиар



Урсгал зардалд урсгал шилжүүлэг 61.1 хувь, бараа үйлчилгээний зардал 29.5 хувь, хүүгийн зардал 6.3 хувь, татаас 3.1 хувийг эзэлж байна. Урсгал зардалд урсгал шилжүүлгийн эзлэх хувь өмнөх оны мөн

үеэс 20.3 пунктээр өсөж, бараа үйлчилгээний зардал 13.0 пункт, хүүгийн зардал 2.0 пункт, татаас 5.3 пунктээр буурсан байна.

Хөрөнгийн зардалд 2021 оны эхний 5 сарын байдлаар 672.3 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 153.5 (18.6%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Хөрөнгийн зардалд 2021 оны 5 дугаар сард 120.9 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх сараас 128.0 (51.4%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Хөрөнгийн зардал өмнөх оны мөн үеэс буурахад барилга, байгууламжийн зардал 231.2 (38.1%) тэрбум төгрөг, их засварын зардал 6.9 (30.9%) тэрбум төгрөг, стратегийн нөөц хөрөнгийн зардал 3.3 (26.7%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна. Харин бусад хөрөнгийн зардал 71.6 (51.4%) тэрбум төгрөг, тоног төхөөрөмжийн зардал 16.3 (35.4%) тэрбум төгрөгөөр өсжээ.


Хөрөнгийн зардалд барилга байгууламжийн зардал 55.8 хувь, бусад хөрөнгийн зардал 31.3 хувь, тоног төхөөрөмжийн зардал 9.3 хувь, их засварын зардал 2.3 хувь, стратегийн нөөц хөрөнгийн зардал 1.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс бусад хөрөнгийн зардлын эзлэх хувь 14.5 пункт, тоног төхөөрөмжийн зардлынх 3.7 пунктээр өсөж, барилга байгууламжийн зардлынх 17.6 пункт, их засварын зардлынх 0.4 пункт, стратегийн нөөц хөрөнгийн зардлынх 0.2 пунктээр тус тус буурчээ.

Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсвийн орлого 2021 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.4 их наяд төгрөг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл 988.7 тэрбум төгрөг болж, орон нутгийн тэнцвэржүүлсэн тэнцэл 411.5 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Орон нутгийн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ашиг өмнөх оны мөн үеэс 178.6 (76.7%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 100.4 (7.7%) тэрбум төгрөгөөр өсөхөд татварын орлого 113.0 (24.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Зураг 5. Орон нутгийн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, тэрбум төгрөг



Орон нутгийн нийт төсвийн орлого, тусламжийн хэмжээ 2021 оны 5 дугаар сард 280.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 10.0 (3.5%) тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 204.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 20.1 (8.9%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 5 сарын байдлаар 997.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 93.9 (10.4%) тэрбум төгрөг, нийт зарлага 1.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 44.4 (4.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого есөхөд тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 172.1 (34.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь нь голлон нөлөөлжээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 5 дугаар сард 184.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 14.0 (8.2%) тэрбум төгрөг, нийт зарлага 210.4 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 2.2 (1.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018 I-V	2019 I-V	2020 I-V	2021 I-V*	$\frac{2021^*I-V}{2020 I-V}$
Нийт орлого	804.5	951.5	903.9	997.8	110.4
Нийгмийн даатгалын сангийн орлого	544.1	699.2	649.7	747.4	115.0
Тусламжийн орлого	260.3	252.3	254.2	250.3	98.5
Нийт зарлага	735.5	838.3	1 002.6	1 046.9	104.4
Бараа үйлчилгээний зардал	7.2	9.8	9.1	10.0	110.6
Урсгал шилжүүлэг	728.3	828.5	993.5	1 037.8	104.5
Эргэж төлөгдөх төлбөрийн хассан цэвэр зээл	-	-	-	- 0.8	-
Тэнцэл	69.0	113.2	- 98.7	- 49.2	49.8

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний 5 сарын байдлаар 389.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 208.6 (2.2 дахин) тэрбум төгрөг, нийт зарлага 391.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 236.3 (2.5 дахин) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2021 оны 5 дугаар сард 88.4 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 4.3 (5.1%) тэрбум төгрөгөөр өсөж, нийт зарлага 93.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 15.8 (14.6%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Хүснэгт 4. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний 5 сарын байдлаар, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018 I-V	2019 I-V	2020 I-V	2021 I-V*	$\frac{2021^*I-V}{2020 I-V}$
Нийт орлого	120.7	174.9	180.9	389.6	2.2¹
ЭМД-ын хураамжийн шимтгэл	120.7	174.9	180.9	389.6	2.2 ¹
Нийт зарлага	121.3	129.1	155.0	391.3	2.5¹
Бараа үйлчилгээний зардал	0.8	1.3	1.5	5.9	4.1 ¹
Татаас	14.7	12.7	13.9	23.5	168.4
Урсгал шилжүүлэг	105.8	115.1	139.6	362.3	2.6 ¹
Эргэж төлөгдөх төлбөрийн хассан цэвэр зээл	-	-	-	- 0.5	-
Тэнцэл	-0.5	45.8	26.0	-1.7	-

¹ Дахин их

Ойлголт, тодорхойлолт:

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, хүний хөгжил сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурал (УИХ)-аас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.

Эх үүсвэр: Сангийн яам

Ангилал, код: Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилал

Тайлбар:

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 7 дугаар сарын 19

Хавсралт:

*Эдийн засгийн статистикийн газрын
Статистикч Ч.Мөнхтуул
Утас (976-51)-261565*

*Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас (976-51)-266414*

